



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/591

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.“г”, Төсвийн тухай хуулийн 14.2.3.заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Мөрөн сумын 7 дугаар багийн иргэн Дашбилэгийн Энхжин 5 сартай тархинд цус харвасан оноштойгоор 3 дугаар шатлалын эмнэлэгт эмчлүүлэх эмчилгээний зардалд 200,000 төгрөг, “Гурван гал” өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 376,050 төгрөг, “Эрүүл ахуйн 3 дадал” аянд манлайлан идэвхтэй оролцсон Мөрөн сумын хамт олны шагналд 200,000 төгрөгийг тус тус олгосугай.

2. Дээрх 776,050 (Долоон зуун далан зургаан мянга тавин) төгрөгийг “Эрүүл иргэн-Эрхэм баялаг” дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Базар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД